



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/298

Арвайхээр

**Зардал хуваарилах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.б, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Эрх шилжүүлэх тухай” 164 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.3.21 дугаарт батлагдсан төрийн захиргааны байгууллагуудын тоног төхөөрөмж (Өвөрхангай, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сум)-д зарцуулах 200 000 000 (хоёр зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100662

Аймгийн Засаг даргын 2020 оны 07  
дугаар сарын 16-ны өдрийн 11200 дугаар  
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦАД БАТЛАГДСАН IV.3.21 ХУУЛИЙН  
ДУГААРТАЙ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД ЭРХ ШИЛЖСЭН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ  
(ӨВӨРХАНГАЙ, БАТ-ӨЛЗИЙ, ХАРХОРИН, ХУЖИРТ, УЯНГА,  
ЗҮҮНБАЯН-УЛААН СУМ) ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төг/
1	Сумдын Засаг даргын Тамгын газар, багийн төвүүдийн тоног төхөөрөмж	80,0
2	Төрийн байгууллагуудын тавилга, тоног төхөөрөмж, компьютер техник хэрэгсэл	120,0
	НИЙТ ДҮН	200,0

-oOo-